



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 2/656

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журмыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тушаалын биелэлтийг хангаж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газар (В.Батчимэг)-т үүрэг болгосугай.

Б.Ба

Б.БАТ-ЭРДЭНЭ

157311363

**ЖУУЛЧНЫ ХӨТӨЧ-ТАЙЛБАРЛАГЧИД ҮНЭМЛЭХ ОЛГОХ,
АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь нь Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Иргэн нь Аялал жуулчлалын тухай хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлж, энэхүү журамд заасан эрх бүхий байгууллагаар мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэлээ тогтоолгон мэргэжлийн жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх авна.

1.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажсан тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

1.4. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь заавал судлах Монгол Улсын тухай ерөнхий мэдлэг, харилцаа, ёс зүй, эмнэлгийн анхан шатны тусламжийн талаар болон мэргэжлийн ур чадварын мэдлэг олгох агуулгыг агуулсан байна.

1.5. Энэ журмын 1.4-т заасан агуулга бүхий ижил төрлийн тусгайлсан сургалтад хамрагдсаныг холбогдох гэрчилгээгээр баталсан иргэн энэ журмын 1.3-т заасан ерөнхий мэдлэгийн сургалтад хамрагдахгүй байж болно.

1.6. Сургалтыг мэргэжлийн сургалтын үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл бүхий байгууллага батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

1.7. Жуулчны хөтөч тайлбарлагчид олгох үнэмлэх, онгорийн томдгийн загварыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

1.8. Жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэхэд овог, нэр, ангилал, зэрэглэл, сургалтад хамрагдсан эсхүл дээд боловсролын гэрчилгээний дугаар, үнэмлэх олгосон огноо бичигдсэн байна. Энгэрийн тэмдэг нь жуулчны хөтөч-тайлбарлагчийн зэрэглэлийг илтгэх өнгө бүхий байна.

1.9. Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх, энгэрийн тэмдэг олгох ажиллагааг зэрэглэл тогтоох байгууллагын шалгалтын үр дүнд үндэслэн нийтийн эрх зүйн хуулийн этгээд зохион байгуулна.

ХОЁР. ЖУУЛЧНЫ ХӨТӨЧ-ТАЙЛБАРЛАГЧИЙН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

2.1. Жуулчны хөтөч-тайлбарлагчийг Ерөнхий аяллын ба Тусгай сонирхлын аяллын гэж ангилна.

2.2.Жуулчны хөтөч-тайлбарлагчийн ангиллыг үл харгалзан мэдлэг, ур чадвар, туршлагыг үндэслэн I болон II зэрэглэл олгоно.

2.3.Тусгай сонирхлын жуулчны хөтөч-тайлбарлагч Аялал жуулчлалын тухай хуулийн 14.2-т заасан даатгалтай, эрсдэл бүхий аяллыг хөтөчлөх бол энэ тухай нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд мэдээлнэ.

2.4.Нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр ангилал зэрэглэлээ тогтоолгосон жуулчны хөтөч-тайлбарлагч нь төрөөс үзүүлж буй аливаа бодлогын дэмжлэг, хөнгөлөлтөд хамрагдана.

ГУРАВ. АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1.Иргэн жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх авах, ангилал, зэрэглэл тогтоолгох хүсэлтээ нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бичгээр болон цахимаар гаргана.

3.2.Жуулчны хөтөч тайлбарлагчийн үнэмлэх авах, ангилал, зэрэглэл тогтоолгох хүсэлтэд дараах материалыг хавсралтаар ирүүлнэ. Үүнд:

3.2.1.Иргэний үнэмлэх;

3.2.2.Аяллын хөтөч тайлбарлагчийн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан гэрчилгээ;

3.2.3.Өнгөт гэрэл зураг 2 хувь;

3.2.4.Эрүүл мэндийн тодорхойлолт.

3.2.5.Аяллын хөтөч тайлбарлагчийн ангилал, зэрэглэлээ тогтоолгох хэлний чиглэлийг тодорхойлсон баримт

3.3.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх авах, ангилал, зэрэглэл тогтоолгох хүсэлтэд энэ журмын 3.2-т зааснаас гадна дараах материалыг нэмэлтээр хавсралтаар ирүүлнэ. Үүнд:

3.3.1.Монгол Улсад оршин суух үнэмлэх;

3.3.2.Монгол Улсад 5 жил оршин суусан талаарх гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны-байгууллагын тодорхойлолт

3.3.3.Монгол хэлний төвшин тогтоох шалгалтын гэрчилгээ.

3.4.Жуулчны хөтөч-тайлбарлагчид ангилал, зэрэглэл тогтоохдоо шалгалт авах бөгөөд шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг нийтийн эрх зүйн хуулийн этгээд тухай бүр байгуулна.

3.5.Жуулчны хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэл тогтоох шалгалтыг хагас жилд I, IV улиралд/ нэг удаа зохион байгуулна.

3.6.Шалгалтын бүртгэлийг цахим хэлбэрээр явуулах бөгөөд бүртгүүлэх зөвлөмжийг ойлгомжтой байдлаар боловсруулж, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлнэ.

3.7.Шалгалтын бүртгэлийн зөвлөмжид бүртгэл дуусах хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар тодорхой заана.

3.8.Шалгалтад бүртгүүлэхтэй холбогдон гарах зардлыг оролцогч өөрөө хариуцах бөгөөд шалгалтын бүртгэлийн хураамжийн хэмжээг нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн Удирдах зөвлөл тогтооно.

3.9.Жуулчны хөтөч-тайлбарлагчийн шалгалт нь ур чадварын болон ерөнхий мэдлэгийн гэсэн хэсгээс бүрдэнэ. Ур чадварын дадлага хэсгийг тухайн жуулчны хөтөч тайлбарлагч өөрийн сонгосон гадаад хэл дээр хийж гүйцэтгэнэ.

3.10.Иргэн эхлээд ур чадварын дараа нь ерөнхий мэдлэг гэсэн дарааллаар шалгуулна. Ур чадварын шалгалтад тэнцээгүй тохиолдолд ерөнхий мэдлэгийн шалгалтад орохгүй.

3.11.Ур чадварын шалгалтаар жуулчны хөтөч-тайлбарлагчийн хэлний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг шалгана.

3.12.Ерөнхий мэдлэгийн шалгалтыг тест хэлбэрээр авах бөгөөд жуулчны хөтөч-тайлбарлагчийн эзэмшсэн байвал зохих мэдлэгийг шалгана.

3.13.Шалгалтын комиссоос гаргасан шалгалтын дүнд үндэслэн шаардлага хангасан иргэнд жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх, энгэрийн тэмдэгийг нийтийн эрх зүйн хуулийн этгээд олгоно.

3.14.Жуулчны хөтөч-тайлбарлагч нь зэрэглэл ахиулах хүсэлтээ нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд гаргаж, шалгалт өгөх бөгөөд шалгалтыг тест болон мэргэжлийн холбоодын шалгаруулалтаар авна.

3.15.Жуулчны хөтөч-тайлбарлагчийн зэрэглэлийн үнэмлэхийг 5 жилийн хугацаагаар олгоно.

3.16.Жуулчны хөтөч-тайлбарлагчийн I болон II зэрэглэлийн ур чадварыг 6 жил хадгалсан хөтөч-тайлбарлагчийн зэрэглэлийг 6 дахь жилээс хугацаагүйгээр сунгаж болно.

3.17.Нийтийн эрх зүйн хуулийн этгээд жуулчны хөтөч-тайлбарлагчийн бүртгэлийг хөтөлж, нэгдсэн мэдээллийг улирал тутам аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

ДӨРӨВ. ШАЛГАЛТЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

4.1.Шалгалтын комиссын бүрэлдэхүүн нь аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага болон аялал жуулчлалын салбарт 10 буюу түүнээс дээш ажилласан жуулчны хөтөч-тайлбарлагч, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл бүхий 10 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

4.3.Шалгалтын комисс шалгалтын агуулгыг тухай бүр шинэчлэн батална.

4.4.Шалгалтын комисс нь шалгалттай холбоотой дараах үйл ажиллагааг явуулна:

4.4.1.шалгалтын товыг нийтэд зарлан мэдээлэх;

4.4.2.шалгалтын талаар мэдээлэл, арга зүйн уулзалтыг хийх, хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

4.4.3.шалгалтад оролцогчийг бүртгэх бэлтгэлийг хангаж, зохион байгуулах;

4.4.4.шалгалтад орох тухай өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөв байдлыг шалгах зорилгоор шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээллийг гаргуулахаар байгууллага, албан тушаалтанд хүсэлт гаргах;

4.4.5.шалгалтын даалгаврын санг бүрдүүлэх, нууцлалыг хамгаалах;

4.4.6.шалгалтын танхим, техник хэрэгсэл, компьютер, болон шалгалт хэвийн явагдах бусад орчин, нөхцөлийг хангах;

4.4.7.шалгалтад ашиглах компьютер, программ хангамжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах;

4.4.8.шалгалтыг зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах иргэн, хуулийн этгээдийг сонгох, тэдгээртэй хамтран ажиллах гэрээ байгуулах;

4.4.9.шалгалтын явцад хөндлөнгийн хяналт тавих, оролцогчтой сонирхлын зөрчилгүй иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг хянагчаар ажиллуулах;

4.4.10.шалгалтад оролцогчийн биеийн байцаалтыг нягтлан шалгах, оролцогчдыг кодоор дугаарлах, суудал хуваарилах;

4.4.11.шалгалтын явцад мөрдөх журам, заавар, удирдамжийг өргөдөл гаргагч, шалгалтад оролцогч болон бусад этгээд танилцах боломжтой байхаар нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн цахим хуудсанд байршуулж, мэдээлэх;

4.4.12.шалгалтын явцад энэ журамд заасны дагуу шалгалтад оролцогчдод хяналт тавих, шалгалтын явцыг баримтжуулах;

4.4.13.шалгалтын үед компьютер, программ хангамжийг ашиглах анхан шатны зөвлөгөө, туслалцааг оролцогчид үзүүлэх, техник, программ хангамж, сүлжээтэй холбоотой эвдрэл, гэмтлийг яаралтай засуулах арга хэмжээ авах;

4.4.14.бодлогын шалгалтын даалгаврыг хэвлэх, нууц кодоор дугаарлах, шалгалтын даалгаврыг дүгнэх комисст хүлээлгэн өгч, нууцлалыг хамгаалах ;

4.4.15.шалгалтын нэгдсэн дүн ба явцын талаар нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон олон нийтэд тайлагнах;

4.4.16.шалгалтын гүйцэтгэлийг дүгнэх, оролцогчийн даалгавар биелүүлсэн шалгалтын материалыг дүгнэсэн аргачлалыг жишиг хариутай хамт нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн цахим хуудсанд байршуулж, мэдээлэх;

4.4.17.шалгалтад тэнцсэн оролцогчдын мэдээллийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хүргүүлэх;

4.4.18.шалгалт зохион байгуулахтай холбоотой бусад.

4.5.Шалгалтын комиссын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд нийт гишүүдийн 75 ба түүнээс хувийн ирцтэй тохиолдолд хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.

4.6.Комиссын хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулан, комиссын гишүүдэд танилцуулсан байна.

4.7.Комиссын хурлын бэлтгэлийг хангах, хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, баталгаажуулах, гишүүдэд танилцуулах ажлыг комиссын нарийн бичгийн дарга хариуцна.

4.8.Шалгалтын комиссын хуралдаанаар энэ журмын 4.4.1-ээс 4.4.18-д заасан асуудлыг хэлэлцэж, тухай бүр тогтоол гаргана.

4.9.Оролцогчийн шалгалт тус бүрээр авбал зохих дээд оноо нь ур чадварын шалгалтад 50, ерөнхий мэдлэгийн шалгалтад 50, нийт оноо 100 байна.

4.10.Ур чадварын болон ерөнхий мэдлэгийн шалгалтад авсан нийлбэр дүн нь 70 ба түүнээс дээш хувьд хүрсэн бол шалгалтад тэнцсэнд тооцно.

ТАВ. ШАЛГАЛТЫН ТОВ, ДҮНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

5.1.Энэ журмын 4.2-т заасан хугацаанд шалгалт зохион байгуулах өдрийн товыг шалгалт эхлэхээс 45 хоногийн өмнө олон нийтэд нээлттэй мэдээлж, нийтийн эрх зүйн хуулийн этгээд цахим хуудсандаа байршуулна.

5.2.Шалгалтын бүртгэлийг цахим хэлбэрээр явуулах бөгөөд бүртгүүлэх зөвлөмжийг ойлгомжтой байдлаар боловсруулж, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлнэ.

5.3.Шалгалтын бүртгэлийн зөвлөмжид бүртгэл эхлэх болон бүртгэл дуусах хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар тодорхой заана.

5.4.Энэ журамд заасны дагуу зохион байгуулсан шалгалтын дүнг шалгалт авснаас хойш 14 хоногийн дотор нийтэд нээлттэй мэдээлж, нийтийн эрх зүйн хуулийн этгээд цахим хуудсандаа байршуулна.

5.5.Нийтийн эрх зүйн хуулийн этгээд шалгалт дууссанаас хойш 30 хоногийн дотор уг шалгалтад тэнцсэн иргэнд Жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх, энгэрийн тэмдгийг олгоно.

ЗУРГАА. ҮНЭМЛЭХИЙГ СУНГАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

6.1. Жуулчны хөтөч-тайлбарлагч нь үнэмлэхээ сунгуулах хүсэлтээ нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд гаргах бөгөөд дараах материалыг хавсаргана. Үүнд:

- 6.1.1. өргөдлийн маягт;
- 6.1.2. хураамж төлсөн баримт;
- 6.1.3. өөрийн үнэмлэхийн хуулбар;
- 6.1.4. харьяалагдах тур операторын тодорхойлолт /боломжтой тохиолдолд/.

6.2. Жуулчны хөтөч-тайлбарлагчийн зэрэглэлийн үнэмлэхийг анх олгосон хугацаагаар сунгана.

6.3. Жуулчны хөтөч-тайлбарлагчийн зэрэглэлийн үнэмлэхийн хугацааг сунгахдаа дахин шалгалт өгнө.

6.4. Дараах тохиолдолд жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэхийн хүчинтэй байдлыг түдгэлзүүлэх арга хэмжээ авна. Үүнд:

6.4.1. Аялал жуулчлалын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн талаар жуулчин аялал жуулчлалын байгууллагаас албан ёсоор удаа дараа гомдол ирсэн;

6.4.2. Аялал жуулчлалын тухай хуулийн 10.3.1-10.3.3.-т заасан үүргээ биелүүлээгүй болох нь жуулчин, аялал жуулчлалын байгууллагаас албан ёсоор удаа дараа гомдол ирсэн;

6.4.3. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан.

6.5. Дараах тохиолдолд жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэхийг хүчингүй болгоно. Үүнд:

6.5.1. Жуулчны хөтөч-тайлбарлагч өөрөө хүсэлт гаргасан;

6.5.2. Аялал жуулчлалын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн;

6.5.3. Аялал жуулчлалын тухай хуулийн 10.3.1-10.3.3.-т заасан үүргээ биелүүлээгүй болох нь жуулчны гомдол, түүний тайлбар, мэдүүлэг, тэдгээрийг нотолсон баримтаар тогтоогдсон;

6.5.4. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон.

6.6. Дараах тохиолдолд жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэхийг сэргээнэ. Үүнд:

6.6.1. Жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэхийн хүчинтэй байдлыг энэ журмын 6.5-д заасны дагуу түдгэлзүүлсэн бол 1 жилийн дараа иргэн хүсэлт гарган дахин шалгалт өгсөн бол;

6.6.2. Жуулчны хөтөч-тайлбарлагчийн үнэмлэхийг энэ журмын 4.5-д туссан заалтын дагуу хүчингүй болгосон бол 3 жилийн дараа иргэн хүсэлт гарган дахин шалгалт өгсөн бол;

6.6.3. Аялал жуулчлалын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн нь тогтоогдоогүй;

6.6.4. Аялал жуулчлалын тухай хуулийн 10.3.1-10.3.3-т заасан үүргээ биелүүлээгүй талаарх жуулчны гомдол, түүний тайлбар, мэдүүлэг нь батлагдаагүй эсвэл буруугүй болох нь батлагдсан;

6.6.5. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдээгүй, буруугүй болох нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Жуулчны хөтөч-тайлбарлагч нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцдаа өөрийн зэрэглэлийг тодорхойлсон үнэмлэх, энгэрийн тэмдгийг биедээ ил харагдах байдлаар авч явна.

7.2. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр зэрэглэлээ тогтоолгоогүй иргэн жуулчны хөтөч-тайлбарлагчийн үйл ажиллагаа эрхэлсэнтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд нийтийн эрх зүйн хуулийн этгээд хариуцлага хүлээхгүй.

7.3. Журмын хэрэгжилтэд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон аялал жуулчлалын улсын байцаагч хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдалд энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.4. Мэргэжлийн үнэмлэхээ зөрчил гарган хүчингүй болгосон жуулчны хөтөч тайлбарлагчийн мэдээллийг аялал жуулчлалын мэдээллийн санд бүртгэн олон нийтэд ил зарлана.

---oOo---



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 2/18

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.12 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журмыг 1 дүгээр, өндөр уулын бүсэд авиралт хийх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалын биелэлтийг хангаж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газар (В.Батчимэг)-т үүрэг болгосугай.

Б.Бат-Эрдэнэ

Б.БАТ-ЭРДЭНЭ

152400050

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2024 оны 01 дүгээр сарын 12 өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэ журмын зорилго нь тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах, түүнийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Аялал жуулчлалын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний бусад актаар зохицуулна.

1.3.Аялал жуулчлалын тур оператор, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, мэргэжлийн холбоод нь тусгай сонирхлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөн бүрдүүлж, багц аяллыг шууд, эсхүл аяллын агентаар дамжуулан худалдах, зохион байгуулах үйлчилгээ эрхэлнэ.

1.4.Тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилалд хамаарахгүй байгууллага нь тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд Аялал жуулчлалын тухай хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлнэ.

1.5.Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч нь стандартад нийцсэн аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг жуулчинд санал болгоно.

ХОЁР.ТУСГАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.Тусгай сонирхлын аялал жуулчлал гэж тусгай мэргэжлийн ур чадвар, техник хэрэгсэл шаардсан аялал жуулчлалын үйл ажиллагааг ойлгоно.

2.2.Тусгай сонирхлын аялал жуулчлалыг өндөр эрсдэл өндөртэй болон эрсдэл багатай гэж ангилна.

2.3.Аялал жуулчлалын байгууллага, аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, түүний гишүүд нь тусгай сонирхлын аялал жуулчлалын чиглэлээр ажилладаг жуулчны хөтөч-тайлбарлагч, сургагч багш, зааварлагчийг улирал бүр чадавхжуулах сургалтад хамруулна.

2.4.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт тусгай сонирхлын аялал жуулчлалыг тухайн газар нутгийн унаган төрх, экологийн даацыг алдагдуулахгүй байх нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан, байгаль орчинд сөрөг нөлөөгүй хэлбэрээр зохион байгуулна.

2.5.Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч нь жуулчныг бүтээгдэхүүн, үйлчилгээ, аяллын явцад үүсэж болох эрсдэлийн талаар үнэн зөв, бодит мэдээллээр сурталчилгааны болон аяллын туршид тогтмол хангана.

2.6.Тусгай сонирхлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулгад дараах мэдээллийг заавал тусгана:

2.6.1.аяллын багийн танилцуулга;

2.6.2.аяллын явцад үүсэж болох эрсдэл болон тухайн эрсдэлээс сэргийлэх зөвлөмж;

2.6.3. аяллын явцад ашиглагдах тусгай төхөөрөмж, техник хэрэгсэл, түүнийг ашиглах заавар;

2.6.4. тухайн аяллын төрөлд мөрдөгдөх стандартын мэдээлэл.

2.7. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт тусгай сонирхлын аялал зохион байгуулахдаа хамгаалалтын захиргаанд энэ талаар мэдээлнэ.

ГУРАВ.ТУСГАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч нь дараах эрхтэй:

3.1.1. аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас авах;

3.1.2. үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэртээ тусгай сонирхлын аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хамтран хөгжүүлэх, дэмжлэг авах хүсэлтээ харьяалах нутаг дэвсгэрийн аймаг, нийслэлийн Засаг даргад гаргаж шийдвэрлүүлэх;

3.1.3. орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн болон онцгой байдлын байгууллагаас тусгай сонирхлын аялал жуулчлалын явцад жуулчны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг авах.

3.2. Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч нь Аялал жуулчлалын тухай хуулийн 15.1, 15.4, 15.6-д зааснаас гадна дараах үүрэгтэй:

3.2.1. Аялал жуулчлалын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хэм хэмжээний акт, хамгаалалтын горимын дагуу байгальд сөрөг нөлөөгүй аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх;

3.2.2. түүх, соёлын хөдлөх болон үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулах, гэмтээх үйл ажиллагаа явуулахгүй байх;

3.2.3. хөтөлбөрийн дагуу тусгай сонирхлын аяллыг зохион байгуулах;

3.2.4. эрсдэлийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, жуулчинд гэрээнд заасан бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх, жуулчинд аюулгүй ажиллагааны зааварчилгааг бүрэн өгч, аюулгүй байдлыг хангах;

3.2.5. эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнсээр үйлчлэх;

3.2.6. үйл ажиллагаанаас үүссэн ахуйн хог хаягдлыг тухайн нутаг дэвсгэрийн зөвшөөрөгдсөн хогийн цэгт ангилж хаях;

3.2.7. тухайн орон нутгийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгжтэй уялдаа холбоотой ажиллах, тавьсан шаардлагыг биелүүлэх, жуулчинд учирч болзошгүй аливаа эрсдэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

3.2.8. аялал жуулчлалын мэдээллийн санд өөрийн холбогдох мэдээллийг үнэн зөв оруулах.

ДӨРӨВ.ТУСГАЙ СОНИРХЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨРӨӨС ДЭМЖИХ

4.1. Аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, байгаль хамгаалагч нь тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг тусалцаа үзүүлэх үүрэгтэй.

4.2. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь байгаль орчин, биологийн олон янз байдалд тулгуурласан тусгай сонирхлын аялал жуулчлалыг төрөлжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх үүрэгтэй.

4.3. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчийн аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг аялал жуулчлалын мэдээллийн санд бүртгэн гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулна.

ТАВ.БУСАД

5.1. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад улирал бүр хүргүүлнэ.

5.2. Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч нь үүсэж болзошгүй эрсдэлийн талаар харьяалах нутаг дэвсгэрийн онцгой байдлын байгууллагад урьдчилан мэдээлнэ.

5.3. Тусгай сонирхлын аяллын явцад байгаль орчинд хохирол учруулсан бол тухайн сум, дүүргийн Засаг дарга учруулсан хохирлыг буруутай этгээдээр Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу нөхөн төлүүлнэ.

5.4. Энэ журмын хэрэгжилтэд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, тэдгээрийн харьяа байгууллага хяналт тавьж ажиллана.

5.5. Журмын хэрэгжилтийн тайланг нийтийн эрх зүйн хуулийн этгээд хагас жил тутам гаргаж, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ӨНДӨР УУЛЫН БҮСЭД АВИРАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Өндөр уулын бүсэд авиралт зохион байгуулах, авиралт хийх чиглэл, хугацааг тодорхойлох, түүнд оролцогчдын аюулгүй байдал, эрсдлийг бууруулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Өндөр уулын бүс гэдэгт далайн түвшнээс 2799 метрийн өндөр болон авиралт хийхэд хүндрэл бүхий уулсыг /цаашид "өндөр уулын бүс" гэх/ багтаах ба эдгээрт аливаа зорилгоор өөрийн биеэр авиралт хийхтэй холбогдсон үйл ажиллагааг хамруулна.

1.3.Энэхүү журам нь Байгаль орчныг хамгаалах тухай, Аялал жуулчлалын тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна.

ХОЁР.АВИРАЛТ ХИЙХ ӨНДӨР УУЛСЫН ЖАГСААЛТ, ЧИГЛЭЛ

2.1.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монголын уулчдын үндэсний холбооны санал, дүгнэлтийг үндэслэн авиралт зохион байгуулах боломжтой өндөр уулсын жагсаалт, авиралт хийх боломжтой чиглэл, хугацаа, авирагчдад тавигдах шаардлагыг баталж, мөрдүүлнэ.

2.2.Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа нь менежментийн төлөвлөгөөндөө тухайн хамгаалалттай газар нутаг дахь батлагдсан өндөр уулс, авиралтын чиглэл, авиралт хийх хугацааг тусгана.

2.3.Өндөр уулын бүсэд батлагдсан чиглэлээс бусад чиглэлээр авиралт хийх тохиолдолд энэ журмын 3.2-т заасан хугацаанд Монголын уулчдын үндэсний холбоонд урьдчилан мэдэгдэж, батлуулна.

ГУРАВ.АВИРАЛТЫН БҮРТГЭЛ

3.1.Өндөр уулын бүсэд хийх авиралт, авиралтанд оролцох уулчин бүрийг Монголын уулчдын үндэсний холбоонд бүртгүүлнэ.

3.2.Авирагч болон авиралт зохион байгуулагч этгээд төлөвлөгөөт авиралт эхлэхээс 10 хоногийн өмнө өндөр уулын бүсэд авиралт хийх хүсэлтээ дараах мэдүүлгийн хамт Монголын уулчдын үндэсний холбоонд мэдүүлнэ:

3.2.1.өндөр ууланд авиралт хийх мэдүүлэг;

3.2.2.амь насны даатгалд хамрагдсан баримт;

3.2.3.насанд хүрээгүй /14-18 насны/ иргэний хувьд эцэг, эх асран хамгаалагчийн зөвшөөрөл, батлан даалт;

3.2.4.уулын авиралтын хөтөчтэй байгуулсан гэрээ;

3.2.5.энэ журам болон журмын 5.1-т заасан зөвлөмжийг авиралтанд оролцогч тус бүрт таницуулсны үндсэн дээр оролцогч тус бүртэй байгуулсан гэрээ;

3.2.6.авирагч тус бүрийг олон улсын уулчдын холбооноос /UIAA/ зөвшөөрөгдсөн стандартын дагуу багийн аюулгүй ажиллагаанд шаардагдах тоноглол, техник хэрэгслээр бүрэн хангасан эсэх талаарх мэдээлэл;

3.3.Монголын уулчдын үндэсний холбоо нь хүсэлт хүлээн авснаас 10 хоногийн дотор, журмын 3.2 дахь хэсгийн бүрдлийг хангасан этгээдийг бүртгэж, бүртгэлийн хуудас олгоно.

3.4.Журмын 3.2 дахь хэсэгт заасан материалын бүрдэл дутуу, тогтсон хугацаанд хүсэлт ирүүлээгүй нь бүртгэхээс татгалзах үндэслэл болно.

3.5.Цаг агаарын урьдчилсан мэдээгээр сонгосон өндөр уулын бүсэд төлөвлөсөн хугацаанд цаг агаарын аюулт үзэгдэл тохиолдож болзошгүй нөхцөлд бүртгүүлэхийг хүссэн этгээдэд мэдэгдэж, хугацааг харилцан тохиролцож, өөрчилнө.

3.6.Бүртгүүлж авиралт хийх бүсэд очсон үед цаг агаарын аюулт үзэгдэл тохиолдож болзошгүй нөхцөл үүсвэл авиралтыг түр түдгэлзүүлж буцаах шийдвэрийг тухайн орон нутгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Тусгай хамгаалалттай нутгийн хамгаалалтын захиргаанд гаргаж хэрэгжүүлэх ба Монголын уулчдын үндэсний холбоо өөр хугацаанд авиралт хийх боломжийг олгоно.

3.7.Өндөр уулын авиралт хилийн бүсэд зохион байгуулагдах бол авиралт зохион байгуулагч Хил хамгаалах ерөнхий газарт хүсэлт гарган холбогдох зөвшөөрлийг авсан байна.

3.8.Өндөр уулын бүсэд авиралт хийх бүртгэлийн хуудсанд заасан хугацаа, сонгосон оргилыг солих, бүртгэлийн хуудсыг өөр этгээдэд шилжүүлэх, авиралтын бүрэлдэхүүнд шинээр оролцогч нэмэхийг хориглоно.

ДӨРӨВ.УУЛЫН ХӨТӨЧ

4.1.Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн болон Монголын уулчдын үндэсний холбооны уулын хөтчийн сургалтад хамрагдаж, үнэмлэх авсан хөтөч /цаашид "хөтөч" гэх/ өндөр уулын бүсэд зохион байгуулагдах авиралтанд хөтчөөр ажиллах эрхтэй.

4.2.Уулын хөтөч нь авиралт хийх оргил, чиглэлээс хамаарч Монголын уулчдын үндэсний холбооны тогтоосон ур чадварын шаардлагыг хангасан байна.

4.3.Хөтөч нь багийн гишүүдэд энэ журмын 5.1-т заасан зөвлөмж, энэ журмын тавдугаар бүлгийг тус тус танилцуулж, дагаж мөрдөхөд дэмжлэг үзүүлнэ.

4.4.Хөтөч нь орон нутгийн байгаль хамгаалагч, хилийн цэргийн ангийн ажилтнаас өгсөн заавар, чиглэлийг баримтлан, багийн гишүүдэд хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, хог хаягдалгүй авиралт хийх талаар зааварчилгаа өгнө.

ТАВ.АВИРАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1.Монголын уулчдын үндэсний холбоо нь өндөр ууланд авиралт хийх аюулгүй ажиллагааны зөвлөмж батална.

5.2.Өндөр уулын бүсэд авиралт зохион байгуулахад энэ журмын 2.1-т заасан жагсаалт, чиглэлийн дагуу авирагчид тавих шаардлагыг хангасан этгээд авиралт хийх ба энэ журмын 5.1-д заасан зөвлөмжийг тус тус баримтална.

5.3.Авиралт зохион байгуулагдах нутгийн байгаль хамгаалагч, хил орчмын нутагт Хилийн цэргийн ангийн холбогдох ажилтан авиралтын хөтөлбөртэй танилцаж, үндсэн отог байгуулах байршил тогтоож, тухайн өндөр уулын бүсийн батлагдсан авиралтын чиглэл, байгалийн бүсийн хөрс, ус, ургамал, амьтны онцлогийн талаар мэдээлэл өгч, хориглох заалтуудыг тайлбарлана.

5.4.Авиралтын багийн ахлагч отгийн хязгаарыг тэмдэгжүүлэн, автомашины зогсоол, хог хаягдал байршуулах түр цэгийг байгуулна. Үндсэн отог буухад хүлээн авсан төлөвт

нийцүүлэн орон нутгийн байгаль хамгаалагчид хүлээлгэн өгч, акт үйлдэнэ. Шаардлагатай бол хүлээн авсан болон хүлээлгэн өгсөн үеийн гэрэл зураг хавсаргана.

5.5.Авиралт зохион байгуулагч, хөтөч, авирагчид Олон улсын уулчдын холбооноос гаргасан уулчны тангараг /манифест/, уулын ёс зүйн тунхгийн зарчмыг авиралтын туршид баримтлах ба авиралт явагдаж буй өндөр уулын бүсэд ул мөр үлдээхгүй байхыг эрхэмлэнэ.

5.6.Үндсэн отгоос хөдөлснөөс хойш буцаж бууж ирэх хүртэлх бүхий л хугацаанд авиралттай холбоотой шийдвэрийг авиралт зохион байгуулагч хөтөчтэй хамтран гаргана.

5.7.Авиралтын багийн гишүүд байгалийн төрхийг алдагдуулах дурсгалын самбар байрлуулах, уул хаданд үг бичих, сийлэх, мод хугалах гэх мэт аливаа сөрөг үйл ажиллагаа хийхийг хориглоно.

5.8.Ан амьтан хороох, өвс ургамлыг гэмтээж устгах, байгалийг бохирдуулан сүйтгэх, ургамлын үр түүж цуглуулах, орон нутгийн иргэдийн соёл, уламжлал, шашин шүтлэгт сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа хийх зэргийг хатуу хориглоно.

5.9.Гал алдах, оч үсрэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, байгаль хамгаалагч, онцгой байдлын ажилтнаас өгсөн заавар зөвлөмжийг чанд мөрдөнө.

5.10.Өндөр уулын бүсэд галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх эд зүйлс авч явахыг хориглоно.

5.11.Өндөр уулын бүсээс авиралтын үед байгалийн бус гаралтай эд зүйл, соёлын өв, түүх дурсгалын болон бусад үнэт зүйлс олдсон тохиолдолд орон нутгийн байгаль хамгаалагчид хүлээлгэн өгнө.

5.12.Уулын хөтөч нь Монголын уулчдын үндэсний холбооноос гаргасан маягтын дагуу авиралтын тухай үнэн бодит тайланг гаргаж өгөх үүрэгтэй.

5.13.Монголын уулчдын үндэсний холбооноос өндөр уулын бүсэд авиралт хийж оргилд гарсан авирагчид гэрчилгээ олгоно.

ЗУРГАА. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

6.1.Өндөр уулын авиралт хийж буй аливаа хувь хүн авиралтын хугацаанд өөрийн аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

6.2.Өндөр уулын авиралт зохион байгуулагч нь оролцогчдын аюулгүй байдлыг хангуулж, бие бялдрын ачаалал даах чадварыг тодорхойлж, урьдчилсан бэлтгэл, дасгалжуулалт хийх асуудлыг хариуцна.

6.3.Өндөр уулын бүсэд авиралт зохион байгуулж буй хувь хүн, хуулийн этгээдэд хяналт тавьж, холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам мөрдүүлэх ажлыг тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, хилийн бүсэд Хилийн цэргийн анги хариуцна.

6.4.Өндөр уулын бүсэд авиралт зохион байгуулах аливаа этгээд энэхүү журмыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд журам зөрчиж, бүртгэлтгүй авиралт хийсэн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага оногдуулна.

6.5.Өндөр уулын бүсэд байгалийн аюулт үзэгдэл үүссэн тохиолдолд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Онцгой байдлын ерөнхий газар, Монголын уулчдын үндэсний холбоо хамтран уялдаа холбоотой ажиллаж харилцан шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлнэ.

ӨНДӨР УУЛЫН БҮСЭД АВИРАЛТ ХИЙХ МЭДҮҮЛЭГ

Монголын уулчдын үндэсний холбоонд:

Нэг. Ерөнхий мэдээлэл

№	Агуулга	Тэмдэглэл
1	Авиралт хийх уулын мэдээлэл, байршил	Монгол Улсын аймгийн сумын нутагт өндөрт орших ууланд чиглэлээр
2	Авиралт хийх хугацаа /он, сар, өдөр/	Отоглох: Дайралт хийх: Дуусах:
3	Уулын багийн нэр	
4	Уулын багийн ахлагчийн нэр	Ургийн овог:..... Эцэг /эх/-ийн нэр.....: Нэр:.....
5	Уулын багийн гишүүдийн иргэншил, хэлний мэдээлэл:	Иргэншил: Төрөлх хэл:..... Бусад хэл:.....
6	Уулын багийн гишүүдийн үндсэн харъяалал	
7	Зардал, ивээн тэтгэгчийн мэдээлэл	
8	Уулын багийн зорилго	
9	Авиралт хийх хүсэлтэй байгаа уулсын нэр болон өндөр	
10	Багийн аяллын маршрут	
11	Багийн сонгосон ууланд авиралт хийх чиглэл	
12	Уулын багийн авиралт эхлэх цаг, үргэлжлэх хугацаа, оргилоос буух товлосон хугацаа	
13	Уулын хөтчийн тоо	
14	Уулын багийн зохион байгуулалтыг хариуцаж буй аялал жуулчлалын үйлдвэрлэлийн үйлдвэр, хаяг, утас	
15	Уулын багийн гишүүд болон техник хэрэгслийг тээвэрлэх	



	тээврийн хэрэгслийн тоо, үйлдвэр, загвар, улсын дугаар	
16	Уулын хөтчийн нэр, үнэмлэхийн дугаар /хуулбар хавсаргах/	
17	Холбоо барих дугаар	

Хүсэлт гаргасан:

Овог, нэр: Гарын үсэг.....

Хаяг:

Цахим хаяг.....

Ажлын утас..... Гар утас.....

Яаралтай үед холбогдох хүний нэр, утас.....

он..... сар..... өдөр.....

Хоёр.Тусгай мэдээлэл (гишүүн тус бүрээр мэдүүлнэ)

№	Агуулга	Тэмдэглэл
1	Багийн гишүүдийн овог, нэр, төрсөн он, сар, өдөр	Ургийн овог:..... Эцэг /эх/-ийн нэр:..... Нэр: Төрсөн.....Он.....сар.....өдөр
2	Регистр (гадаад паспортын дугаар)	
3	Оршин суугаа хаяг	
4	Үндсэн баазад ажиллах болон бусад туслах ажилчдын тоо	
5	Багаж хэрэгслийн жин болон тоо (ойролцоогоор)	
6	Үүрэх ачааны жин	
7	Багт гүйцэтгэх үүрэг	
8	Эрүүл мэндийн мэдээлэл	Цусны бүлэг:..... Бусад суурь өвчтэй эсэх:.....
9	Яаралтай үед холбоо барих байгууллага, хувь хүн	1.Хэн болох: Ургийн овог:..... Эцэг /эх/-ийн нэр:..... Нэр:..... Утасны дугаар:..... 2.Хэн болох: Ургийн овог:..... Эцэг /эх/-ийн нэр:..... Нэр:..... Утасны дугаар:.....

Хүсэлт гаргасан:

Овог, нэр: Гарын үсэг.....

Хаяг:

Цахим хаяг.....

Ажлын утас..... Гар утас.....

Яаралтай үед холбогдох хүний нэр, утас.....

он..... сар..... өдөр.....